



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 07 сарын 04
өдөр

№ 1

Улаанбаатар хот

М.Отгонбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирсэн та бүхэнд талархал илэрхийлэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр 13 цаг 00 минутад Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо “Holiday inn” 19 давхар хурлын зааланд эхэллээ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын ирц болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг журмын дагуу ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайханд удирдан зохион байгуулах эрхийг өгье.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Тооллогын комиссын даргад талархал илэрхийлье. Ингээд эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Тооллогын комиссын тогтоол гарлаа. Хурлын ирц хувьдаа хүрсэн учир хурлыг нээснийг мэдэгдэе.

Өнөөдрийн ээлжит бус хурлаар:

1. Хувьцаа хуваах тухай
2. Нэмэлт хувьцаа гаргах
3. Бонд гаргах тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг батлах тухай гэсэн асуудлууд хэлэлцэгдэнэ.

Ингээд хэлэлцэх асуудлыг 45 хоногийн өмнө зарладаг бөгөөд хэлэлцэх зүйлийн талаар дүрмэнд оруулсан байдаг. Иймд зарлагдсан асуудлаас өөр нэмэлт асуудал хэлэлцэх боломжгүй байдаг. Хэрвээ асуудал хэлэлцүүлнэ гэвэл дүрмийн дагуу хурал зохион байгуулж дараагийн хурлаар хэлэлцэж болох ийм журамтай.

Нэгт: Хувьцаа хуваах төслийг танилцуулна.

Д. Санжаа: Сайн байцгаана уу та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргье. Ногоон хөгжил үндэсний нэгдэл хувьцаат компанид гүйцэтгэх захирлаар ажиллаад 6 сар орчим болж байна. Тус компани хэрэгжүүлж байгаа 3 төсөл байгаа

1. Хувьцаанд орон сууц хөтөлбөр
2. Бизнес оновчлол хөтөлбөр
3. Хувьцаат газар хөтөлбөр



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Төслийн хүрээнд хөрөнгө татах, хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэх компанийг хөгжүүлэхээр нэмэлт хувьцаа гаргах шаардлагатай болсон. Нэмэлт хувьцаагаа дараа дараагийн төслүүдэд хөрөнгө оруулах гэж байгаа. Одоогийн байдлаар манайд нэрлэсэн 1 төгрөгийн үнэтэй зарласан хувьцаа 1 тэрбум ширхэг байгаа үүнээс энгийн нь 700 сая ширхэг, давуу нь 300 сая ширхэг хувьцаа дүрмийн хувьд заагдсан байгаа. Одоо гаргасан хувьцаа нийт 5 сая ширхэг үүнээс энгийн хувьцаа 5 сая ширхэг давуу эрхийн хувьцаа гараагүй. Уг хурлаараа давуу эрхийн хувьцаа гаргах зөвшөөрлөө шийдүүлнэ гэж бодож байна.

Нэгж хувьцааг 100 хувааж одоо байгаа 1 тэрбум зарласан хувьцаа маань 100 тэрбум болж үнээс 70 тэрбум ширхэг энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа нь 30 тэрбум ширхэг болно. Гэхдээ бид энэ их хувьцааг нэг дор гаргахгүй, одоо байгаа гаргасан хувьцаа маань 500 сая ширхэг болно. Давуу эрхийн хувьцаа маань гараагүй байгаа учраас яг энэ хэвээрэй буюу 0 байна. Санхүүгийн зохицуулах хорооны хувьцаа хуваах үнэт цаас гаргах журамтай холбоотой бүх заалтуудыг дагаж мөрдөөд шаардлагатай материалуудыг цуглуулсан. Мөн дээрээс нь хуулийн дүгнэлтэн дор гаргуулахаар хөндлөнгийн хуулийн фирм ирсэн байна.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Давуу эрхийн хувьцаа бол нэн тэргүүн ээлжинд ноогдол ашиг авдаг, Компаний үйл ажиллагаа ашигтай байгаа ашиггүй байгааг үл харгалзан ноогдол ашиг хуваарлагдаж байдаг. Өмнө бид 2018 онд зарласан хувьцааг бүх хувьцаа эзэмшигчдийн хурлаар 52500 ширхэг хувьцаатай байсан, үүний 79% нь ашиг сонирхол нэгтэй этгээдтэй төвлөрсөн, бусад 21% нь жижиг хувьцаа эзэмшигчид буюу 130 гаруй хувьцаа эзэмшигчтэй ийм компанийг анх үйл ажиллагааг нь өөрчлөн зохион байгуулаад явж байгаа. 1991 онд хувьцаат компани болсон. Үүнээс хойш хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны арилжаа байгаагүй ийм хэмжээтэй явсан. Ингээд 2018 онд хувьцааг нь 100 хуваасан. Өөрөөр хэлбэл одоогийн гаргасан байгаа 5205600 хувьцаа бол 52 мянган ширхэг хувьцааг 100 хуваагаад ... за хувьцааг хуваах нэгтгэх гэсэн 2 арга байгаа. Хувьцаа хуваахад том жижиг ямар ч хувьцаа эзэмшигчид хохирол байхгүй. Нэгтгэхэд бутархай тоо гараад хаягдах асуудал байдаг. 2018-2019 онд компани нь арилжааны 45 хоног өдөр бүр 15%-р нэмэгдээд 7.5 сая төгрөгийн үнэлгээтэй компани болж байсан.

Одоо хоёр дахь удаагаа хувьцаа хуваах асуудлийг оруулж ирж байгаа шалтгаан нь Санжаа захирлын хэлсэнчлэн хувьцаат орон сууц хөтөлбөр газрын эдийн засгийн эргэлтэнд оруулах хөтөлбөрүүд дээр хөрөнгө нэмж хувьцаа гаргаж хөрөнгө оруулах гэхээр өнөөдрийн нэрлэсэн үнийг нь бодоод үзэхээр нэмсэн хөрөнгө нь төсөлд хангалттай хөрөнгө оруулалт болж чадахгүй байгаа. Ингэхээр өмнө байсан хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөж эхлэнэ. Тиймээс 100 хуваахаар дахин 520,560,000 хувьцаатай болж нэмэлтээр 30 сая ширхэг давуу хувьцаа гаргахад энэ нь нийт гаргасан хувьцааны 8 хувь болж байгаа учир өмнөх хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хувь хэмжээнд маш багаар өөрчлөлт ордог.



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Бидний хамгийн том асуудал бол цаг хугацааны асуудал байгаа. Бид энэ асуудлыг өнгөрсөн жилээс хойш ярьж байгаа, энэ ажлыг маш олон компанитай зөвшилцөж хийдэг. Өмнө нилээн хэдэн удаагийн хурал дээр хувьцаа хуваахтай холбоотой шийдвэрүүдийг гаргасан. Юун дээр очоод гацсан бэ гэхээр Компанийн тухай хуулийн “хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх”, “төлөөлөн удирдах зөвлөлийн эрх” гэдэг зүйлүүд дээр нэмж хувьцаа гаргах асуудал бүрэн эрхэнд нь байгаад байсан. Манай зарласан хувьцаанаасаа гаргаж байгаа үед ТУЗ ганцаараа шийдвэрлээд явж болдог байсан, энэ өөрчлөгдсөнөөр бид найдвартайгаар маш удаан ажиллагаагаа хийж гүйцэтгэж байгаа.

Татан төвлөрүүлэх хөрөнгөө бодоод үзэхэд дахиад нэг процесс байгаа. Одоогийн арилжаан дээр байж байгаа 100 төгрөгийн үнэтэй хувьцааг 100 хуваахаар 1 төгрөг болж байгаа, баланс дээрээ болоод ирэхээр -159 гэж явж байгаа. Тэгэхээр одоо бид энэ нэмэлт хувьцааг гаргасны дараа 10 тэрбум төгрөгийн хаалттай хүрээнд давуу эрхийн хувьцаа гаргана гэж байгаа. Тэр хувьцааг бид орж ирсэн 10 тэрбум гаран төгрөгийн үл хөдлөх хөрөнгөн дээр нь суурьлуулангуут манай нэгж хувьцааны бичилтийн үнэ өндөр болж ирнэ. Өөрөөр хэлбэл 10 тэрбум төгрөгийг хувьцаандаа хөрвүүлээд ирэхээр манай хувьцааны үнэлгээ үнэлгээгээр өснө.

Хоёр дахь асуудал нь хувьцаан дээр суурилсан дээр хөрөнгө босгох төсөл хөтөлбөрүүдийг дахин зарлана. 9 салбарын 27 хөтөлбөр байгаа ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гадаад харилцаа явагдаагүй Гадаад хөрөнгө оруулалтынхаа асуудлуудыг дахиж шинээр хийгээд явж эхлэж байна. 300 сая ширхэг давуу эрхийн хувьцааг бүгдийн гаргая гэсэн ч хөрөнгийн зах зээл дээр баланс байгаа 55% нь энгийн хувьцаа, 45% нь давуу эрхийн хувьцаа байх ёстой гэсэн учир балансийг нь алдагдуулчихаад байна. Тиймээс бид нар 300 сая ширхэг давуу эрхийн хувьцаа гаргах боломжтой. Ийм ашиг тустай зүйлүүд байгаа. Манай компани 1 тэрбум төгрөгийн үнэлгээтэй компани болох нь гэж ойлгож болно.

Одоо бид 30 тэрбум давуу эрхтэй хувьцааны нэгжийн үнийг 1000 төгрөгөөр тогтоож байгаа, энэ нь 30 их наяд төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлнэ. Энэ манай компанид яаж бий болох боломжтой вэ гэвэл Компанийн тухай хуулинд “хувьцааны хөрөнгө оруулалтыг мөнгөөр, үл хөдлөх хөрөнгөөр, үл хөдлөх хөрөнгийн эрхээр, оюуны өмчөөр төлбөр тооцоо хийж болно” гэж заасан. Бид 25 мянган орон сууцны хөтөлбөрөө, орон сууцны хөрөнгө, эрхээрээ энэ төлбөрүүдийг хийлгэж болно.

Хувьцаа хуваах дүрэм, тогтоол уншиж сонсгосон.

Өнөөдөр энэ тогтоолийн нэмэлт өөрчлөлтөө батлан гаргана. Энэ 3 дугаар заалттай холбоотой журмын танилцуулгыг Санжаа захирал товчхон хэлнэ.

Д.Санжаа: Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт заас бүртгэлийн журам” шинэчлэгдэж байгаа. Хувьцаа хуваахад ТУЗ-д бүрэн эрх нь байгаа үүнтэй уялдаад



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаа хуваах үйл ажиллагаа гүйцэтгэх журмаа өөрсдөө боловсруул гэсэн шаардлагыг тавьж байгаа. Энэ журмыг боловсруулсан. Үүнийгээ Санхүүгийн зохицуулах хорооноос заавар аваад мөн хуулийн фирмтэй хамтарч гаргаж ирсэн. Бүгдэнд нь майлээр хүргүүлсэн байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаас бүртгэлийн журамд хувьцаа хуваахтай холбоотойгоор тооцооллуудыг заавал ирүүлсэн байх ёстой. Тэрийг хувьцаа хуваах төсөл хэлбэрээр оруулаад тэр тооцоонууд нь орсон байгаа.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Хувьцаа хуваах журам маань ерөнхий 5 зүйлтэй 4 бүлэг заалтуудтай журам байгаа. Гол заалтуудыг нь хэлэхэд шийдвэр хаагуур гарахыг нь мэдээж хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч байна, мөн төлөөлөн удирдах зөвлөлд ямар эрхийг өгч байгаа, яг энэ ажлыг бодит ажил хэрэг болгоход гүйцэтгэх удирдлага ямар ажлуудыг хэдийд хийх гэх мэт ажлын процесстэй холбоотой үнэт цаас гарсаны дараа хувьцаа эзэмшигч дээр хувьцааг нь яаж бүртгэх, хадгалах гэсэн ийм хэсэгтэй заалтуудтай. Дээрээс нь хувьцаа хуваахтай холбоотой гарах дотоод мэдээллийг компаний тайлангуудыг аваад шууд танилцах эрх бүхий томоохон хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд ойрхон байх боломж тэдгээрээс бусдаас илүү хожих тэр зүйлийг хаасан заалтууд байгаа. Тухайлбал: “дотоод мэдээлэл эзэмшигчийн үүрэг хариуцлага”, “нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийн эзэмшигч ТУЗ-ийн гишүүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, энэхүү журмын 4.1.1-д заасан хувьцаа эзэмшигчдийн хуулийн этгээдийн албан тушаалтан, нэгдлийн оролцогчид хувьцаа хуваах ажиллагаанд ажил үүргийн дагуу оролцож үнэт цаас гаргахтай холбоотой албан тушаалтан, мэргэжилтэн” гэж зааж өгсөн байгаа. Та бүхэн нэг зүйлийг сайн ойлгоорой том хувьцаа эзэмшигч жижиг хувьцаа эзэмшигч яг адилхан эрх эдэлж тэгш оролцоно.

Хоёр дахь нь давуу эрхийн хувьцаа гаргах, хадгалах, хадгалуулах журам. Үүнийг сайтаар ороод танилцаарай.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Нэгдүгээрт №1 тогтоолын төслийг батлах уу, Санал хураалт явуулъя мөн саналын хуудсаараа саналаа өгөөрэй. Нэгдүгээр тогтоол батлагдлаа

Хоёр дугаар асуудал : “Нэмэлт хувьцаа гаргах тухай” №2 дугаар тогтоолын төслийг уншиж сонсгосон.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Нэмж хувьцаа гаргахтай холбоотой 5 бүлэг заалт байна.

Д. Санжаа: Журамтай болон нэмэлт хувьцаа гаргахтай холбоотойгоор нэмэлт тайлбар хэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны журам дээр хувьцааг хувьцаа гэж үзэж байгаа тул давуу, энгийн ялгаагүй хувьцаа гаргах журмаараа явна гэдэг чиглэлийг өгсөн. Тиймээс бид бодлогын хүрээнд 20 сая ширхэг давуу эрхийн хувьцаа, хаалттай



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

хүрээнд 10 сая ширхэг давуу эрхийн хувьцаа гэдэг маань бас учиртай хийгдсэн. Учир нь өмнө нь давуу эрхийн хувьцаа гарч байсан кейс огт байхгүй. Давуу эрхийн хувьцаан дээр одоогийн байдлаар 9.1 тэрбум төгрөгийн захиалга ирсэн байгаа. Тэгэхээр 10 сая хаалттай давуу эрхийн хувьцааны зөвшөөрлөө аваад хувьцаа гаргалаа гэхэд хурдан биелэх магадлал өндөр байгаа. Үүн дээр гадаадын 2 хөрөнгө оруулагч нэрээ оруулсан байгаа.

Эхний хувьцаа хуваах тогтоол дээр дүрмийнхээ шинэчлэлтийг дэс дараалалд оруулж өөрчилж байгаа үүний дараа нэмэлт хувьцаа гаргах энэ тогтоолоороо ТУЗ-д эрхээ өгч байгаа. Учир нь нэмэлт хувьцаа гаргах тутамд зарласан хувьцаан дотроо нэмж хувьцаа гүйлгээнд гаргах тутамд ТУЗ-ийн шийдвэрээр гарч ирнэ. ТУЗ-ийн шийдвэрийг холбогдох байгууллага Улсын бүртгэлд өгөөд дүрмэнд тоо өөрчлөгдөж байгаа учраас зөвхөн тоон үзүүлэлтийг өөрчилнэ гэдэг энэ эрхээ ТУЗ-д шилжүүлж байна л гэсэн үг.

Давуу эрхийн хувьцаа гаргах, хадгалах, хадгалуулах журмыг мөн адил Санхүүгийн зохицуулах хорооноос чиглэл авч холбогдох хуулийн байгууллагатай хамтарч боловсруулсан. Энэ журмаар давуу эрхийн хувьцааг хаана хадгалах, яаж арилжих, бүртгэх гэх мэт бүх заалтыг оруулсан. Иймд дараа дараагийн төсөл хөтөлбөр дээр эрх зүйн бичиг баримттай холбоотой асуудал гарахгүй.

Өмнөх 3 сард Санхүүгийн зохицуулах хороо “танайх хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр яг тодорхой тоог нь зааж өг, зааж өгөөгүйгээс жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөх боломжтой” гэсэн учир одоогийнх дээр яг тоо зааж өгч байгаа.

Компанийн тухай хуулиар давуу эрхийн хувьцаа гаргах үнийг тогтооход ТУЗ шийддэг. Үүн дээр Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлтэй үнэлгээний компанийн үнэлгээг үндэслэл болгож болно гэсэн заалт нь бас орсон байгаа. Манай компаний төслийг үнэлээд тэр үнэлгээн дээр ТУЗ өөрөө 1 ширхэг хувьцааны үнийг тогтооно. Мөн давуу эрхийн хувьцаа хэзээ энгийн хувьцаа руу хөрвөх үү гэдгийг батлана.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Манай төсөл хөтөлбөр том хувьцаа эзэмшигчдээс илүү бага хувьцаа эзэмшиж байгаа хүмүүстэй түрүүлж хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр явж байгаа. Үүнтэй холбоотой таницуулгыг хангалттай өгсөн тул санал хураая

Төслийг баталлаа.

3 дугаар асуудлын хүрээнд “Бонд гаргах тухай” тогтоолийн төслийг уншиж сонсгох

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Бид өмнө нь бонд гарганаа гээд гаргасан. Хаалттай гэж бид нар хоорондоо ярьдаг гэхдээ тийм нэр томъёо байхгүй. Орон сууцжуулах хөтөлбөр дотроо оруулаад бондоо арилжаалах процесс хийсэн. 700



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

гаран сая төгрөгийн бонд арилжаалсан. Тэр арилжаалсан бондын хугацаа хүү бодогдоод явж байгаа. Тэр бол зөвхөн бичилт хэлбэрээр хийгдээд явчихдаг. 6 сар тутам хүү нь нэмэгдэж бодогдоод та бүхний нэр дээр бичигдээд явж байгаа. Тэнд бол ямар нэгэн асуудал байхгүй. Тухайлсан бүртгэлийг холбогдох ҮЦК-аар хийлгэж байгаа.

Санхүүгийн зохицуулах хороо бонд гаргалтын журмыг шинэчилсэн. Тэрэнд бид нарийн томъёолоод байгаа хаалттай бонд байхгүй болж байгаа. 700 сая бонд байхгүй болж байна гэсэн үг биш энэ бол биржийн болон биржийн бус арилжаагаар хийгдээд явдаг. Монсек ҮЦК-аар биржийн бус арилжаагаар явж байгаа асуудал зүгээр одоо бид нарын хаалттай гээд байгаа биш цаана явагдаж байгаа биржийн, биржийн бус гэдэг 2 аргаар 2 уулаа нээлттэй гарч байна гэсэн үг. Хоёулан дээр нь гарах боломжтой байгаа энэ бас цаг хугацаатай байдаг учраас 10 тэрбум төгрөгийн бонд гаргаж байна. Хөрөнгийн зах зээл дээр компани байгаа учраас хөрөнгийг гаргаж байдаг бүтээгдэхүүн юм. Бүтээгдэхүүн гаргадаг компани болоод богино хугацаатайгаар, урт хугацаатайгаар худалдаж авдаг болоод байх юм бол энэ компанийн хувьцааны өсөлт сайн байх учраас энэ зах зээл дээр өнөөдрийн хэрэглэгдэж байгаа бүхий л төрлийн үнэт цаасыг бид гаргадаг байа гэсэн асуудал ярьж байна. Тэрний төлөө манай компани ажиллаж байна. Энэ мөнгийг оруулж ирнэ. Хувьцаат орон сууц төсөлдөө зориулна. Дээрээс нь орж байгаа модон барилгын үйлдвэр, метал хог боловсруулах үйлдвэр байгаль орчны нөхөн сэргээлтийн процесс гэх мэт оруулаад төлөөд яваад байх богино хугацааны өрийн хэрэгсэл учраас бид бондыг байнга авч яваад байгаа шүү. Үүнийг бас ойлгоорой. Бид жишээлбэл өнөөдөр банкнаас зээл аваад хүү төлдөг байдлыг халья хэмээн ярьж байна тэгсэн мөртлөө яагаад ингээд бондод хүү төлөөд байгаа юм бэ гэхээр бид хувьцаа эзэмшигчдээ бондын хүүгээр хөрөнгийг нэмэх процесс бидний хийж байгаа чиглэлд таарсан зүйл гэсэн үг.

Д.Санжаа: 10 тэрбум төгрөгийн бонд гаргаж байгаа шалтгаан гэх юм бол хуулийн этгээд тул хуулийн хүрээнд явж байгаа хуулин дээр компани үндсэн хөрөнгийн хэмжээнээс илүү хэмжээний бонд гаргаж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэр гаргасан байх ёстой. Тэр хүрээнд 1 дүгээр заалтыг биелүүлж байгаа гэсэн үг. 2-т хувьцаа эзэмшигчдэд зориулсан бондын хүрээнд аль болох хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргаж байгаа санхүүгийн зохицуулах хорооны журмаар хаалттайгийн хаалттай бонд гэдэг зүйлийг байхгүй болгож байгаа. Эсхүл хаалттай бирж дээр аль эсвэл нээлттэй бирж дээр яв гэдэг 2 ангилал өгч байна. Бидний гаргаж байгаа бонд бол 2 дах зах зээл дээр худалдаж болдог. Компанийн ТУЗ-ийн зүгээс ирсэн чиг үүргийн дагуу хүүгүй эх үүсвэрийг эрэлхийл гэсэн. Бондыг 1-3 жилийн хугацаатай гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Бондын тогтоолын төслийг батлах уу

Хувьцаа эзэмшигчид: Баталъя



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: 4 дэх хэлэлцэх асуудал. Компанийн үйл ажиллагааг дандаа сайжруулахын тулд хүмүүс 9 гишүүнтэй байсан ТУЗ-ийг 15 гишүүнтэй болгож байгаа юм бэ? 9 гишүүн нь 25000 орон сууц хөтөлбөрийн 5000 багш, 3000 эмч, 2000 малчин, 2000 тээвэрчин гээд 10 ажил мэргэжлийн хүмүүс орохоор төслүүд болоод явж байгаа учраас энэ салбар салбарын төлөөлөгчид бас энэ ТУЗ-д орж яваа гэдэг утгаар ТУЗ-ийн тоог нэмсэн. Орон сууц 3 том үндсэн дэд хөтөлбөрөөс гадна хоол хүнс хувцас хунар өдөр тутмын хэрэглээний зүйл, эрүүл мэнд гээд 5 дэд хөтөлбөр хэрэгжих учраас энэ олон бизнесийн байгууллагууд оролцох юм байна. Энэ талаасаа төлөөлөл байх ёстой гэдэг утгаар ТУЗ-ийн гишүүдийг нэмсэн. Дээрээс нь ТУЗ-ийн гишүүд нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, цалин урамшууллын хороо гээд 3 үндсэн хороодтой хуваагдаж ажиллаж байгаа. Энэ хүмүүсийг бас компанийн шийдвэр гаргалтын идэвхтэй оролцдог байхаар хийж байгаа 3 ажлын хэсэг байгаа хувьцаат орон сууц хөтөлбөрийн ажлын хэсэг, энэ ТУЗ-ийн гишүүдээс гадна тухайн салбарын хамгийн тэргүүний мэргэжлийн ажлын хэсгүүдэд оролцуулж авч явж байгаа энэ утгаараа ТУЗ-ийн үйл ажиллагаа өнгөрсөн 2018 -2022 оны өмнөх 4 жилийн ТУЗ-ыг бодвол хүмүүсийн тоо нэмэгдсэн. Ачаалал нэмэгдсэн. Өнөөдрийн үйл ажиллагаа явагдахад аливаа үйл ажиллагааны үнэ ханшууд нэмэгдсэн гэдэг утгаар нь явж байна. Энэ утгаараа ТУЗ-ийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэж өгдөг байгаа шинээр 15 гишүүнтэй байгуулагдсан ТУЗ-ийн цалин урамшууллын зардлын системийн хэлэлцэе. УЗ-ийн даргын цалин бол компанийн системийн оргил гэж явдаг. 2022-2026 он хүртэлх 4 жилийн эрхтэй байна. Бидний боловсруулсан журам Бизнесийн модел, бикнесийн загварыг компани Зохиогчийн эрхтэй, оюуны өмчөөр баталгаажуулсан бүтээл гаргаж байгаа. Энд байгаа бүх нягтлан бодох бүртгэл нь олон улсын стандартад нийцэж буй, дээрээс нь монгол улсад төдийгүй гадаадын зах зээлд шинэ хөрөнгийн асуудал яригдаж буй энэ процессийг бодож боловсруулсаны хийсны дараа бол бүтэн цагаар хийж ажиллаж байгаа. Энэ асуудлыг 2024 он хүртэл хийж дуусгана. Зардлыг батлахдаа ТУЗ-ийн дарга цалин авдаггүй болно. Дараагаар ТУЗ-ийн даргын цадин үйл ажиллагаанд зарцуулагдана.

Одоогийн байдаар ТУЗ-ийн эдийн засгийн чиглэлийн зөвлөх, хөрөнгийн зах зээлийн зөвлөх, технологи талын зөвлөх хэмээгээд тухайн салбарын хамгийн тэргүүний энэ утгаараа сайн боловсон хүчинг авч ажиллуулах хүсэлтэй байна. Бүх ажиллагаа хөрөнгийн зах зээд дээр анхдагч байгаа энэ зөвлөхүүдийг авснаар илүү чанаржуулна. 2024 оноос энэ ажиллагаа үндсэндээ жигдрэнэ. Гэрээ, хувьцааг гаргана.

ТУЗ-н нарийн бичгийн даргагүй 2-3 жил явлаа. ХЭХ-ын процесс хамгийн том шахаж барьж нийлүүлж байх хүн бол мэргэжлийн хүн байдаг. Бүрэн цагаар ажиллах орон тооны ажилтан байх ёстой. Мөн мэргэжлийн олон хэлтэй хүнийг авах гишүүд улиралдаа нэг сууж байгаа 14 гишүүний улиралын 1 удаагийн урамшуулал 200,000 төгрөг байна. Энэ тал дээр ТУЗ-ийн гишүүд саналаа



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

хэлээрэй. Сардаа бичиг хэргийн зардал 4,000,000 сая орчим төгрөг болж байна. Унаа томилолт гэх мэт зардал гарч ирж байна. Жилээр тооцвол 107,000,000 сая төгрөг, компанийн орлого сар бүрт нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт ороод ирэхээр орлогын шилжих төлбөрүүд орлого руу орж ирнэ. 1000, 1000 аар багцлахад мөнгөн урсгал 500 гаруй сая байгаа. Ковидын нөхцөл байдлаас томоохон хүндрэл гарч ирсэн буцаад сэргэж байна. 2022 оны 01 дүгээр сараас шинээр гэрээнүүдийг хийнэ гэж байсныг хойшлуулсаар байгаад одооноос хийж эхэлж байна. Ингээд компанийн сар бүрийн мөнгөн урсгал 1 тэрбум төгрөгийн 2022 онд 700-800 сая төгрөгөнд хүрэх байх энэ цалингийн фонд гараад ирэнгүүт гүйцэтгэх удирдлагын цалингийн жишиг гараад ирнэ. Энэ дээр саналаа хэлээд уг тогтоолыг батлах уу?

4 дүгээр асуудлаар та бүхний саналыг сонсьё:

Д.Санжаа: Энэ зардлыг гайгүй зардал гэж бодож байна. Эрсдэлийн шинжээч авьяа гэхээр цалин 2,500,000 төгрөг болчоод байна. Тэгэхээр одоо ТУЗ-ийн даргын цалин 2 сая төгрөг байна. ТУЗ-ийн зардлыг энэ хурал дээр батлаад төсөвлөсөн зардал дээр оруулаад өгвөл сайн байх гэсэн саналтай байна. Гадаад хэлтэй чадварлаг боловсон хүчин авах шаардлагатай. Гүйцэтгэх ажиллагаандаа анхаар ажиллах шаардлагатай байна.

ТУЗ-н гишүүн Нэргүй: Цалинг нэмэх шаардлагатай. Даая гэвэл хөрс суурин дээр гэрээ, контракт энэ зорилтыг хурдавчлах хэрэгтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг идэвхжүүлэх шаардлагатай байна.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Компанийн хөдөлмөрийн дотоод журмаар ажиллах хугацааг хүртэл санхүүгийн тэдэн хувиар санхүүжүүлнэ гэсэн үг тул тэр утгаар санхүүжүүлнэ. Нарийн бичгийн даргын цалинг 2 сая 500 төгрөг дээр тавьж байж чадварлаг хүнийг авч ажиллуулна.

Д.Санжаа: ТУЗ дээр төсөвлөсөн бланс дээр саналаа оруулж явсан дээр гүйцэтгэх удирдлага дээр ачаалал ирж байна. Тогтоолын төсөл дээр ТУЗ дээр батлуулж байж ТУЗ-ийн даргын цалингаас бусад зардлыг гүйцэтгэх удирдлага саналаа оруулж баталдаг байх саналтай байна.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг санал болголоо шүү. Энэ бол 9 сая 500 мянга болох юм байна. ТУЗ-ийн гишүүдийн нэмэлтийг батлаад 10 саяаар батлъя гэдэг тооцооллыг тавих уу? Дотор нь багтаагаад

Нэргүй: Цалингийн үйл ажиллагааг хурлаар батлах ёстой асуудлыг төсөл хөтөлбөрөөр ажил удааширана.

Д.Санжаа: Банк санхүүгийн байгууллагатай харьцаад ирхээр Төсөвлөсөн бланк сарын орлого гараад ирнэ шүү дээ. ХЭХ-аар баталсан энэ зардлыг зайлшгүй тусгана гүйцэтгэх удирдлагын албаны зардлыг наана цаана гээд харагдах



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

байдлаас нь гаргаад ирж болно. тэгэхээр ХЭХ-аар ийм зардал баталсан хөдөлгөөнгүй зардал байна хэмээн бага зэрэг хөдөлгөөн оруулж байвал болохоор байна.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Дээд хязгаарыг 10 сая байлгана.

Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл Нацагням: Үндэслэлтэй тоо оруулж байгаа байлгүй дээ. Нарийн бичгийн цалинг тусгаад ямар үндэслэлээр нэмж байна, нэмэхгүй байна гэсэн асуудлыг ойлгохгүй байна. Албан ёсоор сардаа 2 удаа хуралдах асуудал улиралдаа хэдэн удаа хуралдаад байна.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Ээлжит хурал улиралдаа 1 хуралдаж байна. Шаардлагатай бол 7 хоногтоо нэг удаа хуралдаж байна. ТУЗ- улиралдаа хэдэн ч удаа хуралддаг байгаагаас шалтгаалаад ТУЗ-ийн нарийн бичгийн дарга байхгүй байна. Мэргэжлийн ажил тул 2, 3 аргаар авах гэж үзсэн. Орон тоо зарлаж байж авах асуудал байна. Ажлын байрны сонгон шалгаруулалт хийнэ. ТУЗ-ийн дарга бүтэн цагаар ажиллаж байна. Бүх төслийг миний бие бодож боловсруулсан тэр ч утгаараа зохиогчийн эрхийн асуудал яригдаж байна. Цалингийн фонд дээрээс доошоо яригдаж байгаа учраас том зорилгын төлөө ажил хийж байгаа хүмүүсдээ цалин урамшууллыг өгч чаддаг байх шаардлагатай байна. Бизнес хөтөлбөрүүд манай төсөл хөтөлбөрүүдийн загварыг гадаадын улс орон авья гэсэн саналтай байна.

Д.Санжаа: гүйцэтгэх захиралын үйл ажиллагааг хариуцаж аваад 6 сар болж байна. Тухайн Хувьцаат орон сууц хөтөлбөрийн журмуудыг шинэчлэх шаардлага гарсан. Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг шинээр боловсруулсан байгаа. Энийг биет хөрөнгөөр бүртгүүлээд хурлаар батлагдсанаар олон улсын стандартын дагуу бодлогын баримт бичгийн хүрээнд явагдана. Хөрөнгө татах асуудал ойлгомжтой болж ирж байгаа юм. Гадаадын бирж дээр хөрөнгө гаргаж ажиллагаа явагдана. ХОС хөтөлбөрүүд дээр гүйцэтгэх захиралын удирдлагын баг бол төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа. Багш нарын холбоо, Эмч нарын цэгц танхим, цэргийн холбоо хүч түрэн орж байна.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: 4 асуудал амжилттай хэлэлцэж баталлаа. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал байвал хувьцаа эзэмшигчид 5 хараат бус гишүүнээр дамжуулаад санал байвал хэлэлцүүлж болно. Ямар нэгэн асуудал байх юм бол хурал зарлаад хэлэлцэгдээгүй асуудлыг хийх боломжтой. Тараасан саналын хуудас тооцно. Саналын хуудас СЗХ дээр тоологдоно. ХЭХ аас гадна өдөрлөг гэж зохион байгуулна. Амжилт бүтээлтэй өдөрлөг хийе гэсэн төлөвлөгөөтэй байна.

М.Отгонбаатар: За санал хураалтын дүнг гаргалаа. 2022 оны 07 дугаар сарын 04-ны өдөр Эчнээгээр санлаа өгсөн болон танхимын ирцээс авсан санал хураалтын дүнг танилцуулая гээд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын дүнг танилцуулав.



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Үүгээр манай хэлэлцэх асуудал дуусч байна. 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал өндөрлөсөнийг үүгээр мэдэгдье. Хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа. Цаашдаа мөн адил идэвхтэй байна гэж найдаж байна.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН
ХЯНАСАН

Ж.БАТЖИЛ
Д.САНЖАА

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН